



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/588

Улаанбаатар хот


Ажлын баг, хяналтын инженер томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8.2, 11.1 дэх хэсэг, ИНД-172 "Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт" дүрмийн 172.157, ИНД-171 "Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллага - үйл ажиллагаа ба гэрчилгээжүүлэлт" дүрмийн 171.79.(а)-6.3, Холбоо, навигац, ажиглалтын албаны "Үйл ажиллагааны заавар"-ын 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар нислэгийн хөдөлгөөн удирдах төвийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нислэгийн хөдөлгөөний удирдах төвүүдтэй /AIDC/ тоон өгөгдлийн холбоогоор холбох техникийн холболтыг 2018 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн UTC 00:00 цагаас эхлэн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн UTC 16:00 цаг хүртэл Нислэгийн хөдөлгөөний удирдлагын автомат систем /AIRCON2100/-д түр холбон тест, хэмжилт, хяналт шалгалт, туршилт хийх ажлын баг, хяналтын инженерийн бүрэлдэхүүний нэрсийг хавсралтаар баталсугай.


2. Дээрх туршилтын ажлыг хийхдээ төлөвлөгөөний дагуу ашиглалт, техникийн бэлэн байдлыг хангаж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрсдэлгүйгээр зохион байгуулан ажиллахыг Холбоо, навигац, ажиглалтын алба /Д.Баяртогтох/-нд, нислэгийн хөдөлгөөний удирдлагад сөргөөр нөлөөлөхгүйгээр аюулгүй ажиллагааг хангаж, зохих хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба /П.Мөнхжаргал/-нд, нислэгийн үйл ажиллагаатай холбоотой зохих байгууллагуудад зарлан мэдээлэх ажлыг зохион байгуулахыг Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба /П.Ариунгэрэл/-нд тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газар /Ё.Эрдэнэбат/-т даалгасугай.



Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2018 оны 9 дүгээр сарын ...17-ны өдрийн
А/388 дугаар тушаалын хавсралт



Ажлын баг болон хяналтын инженерийн бүрэлдэхүүн

Инженерийн багийн ахлагч:

Б.Мөнхбаяр Холбоо, навигаци, ажиглалтын албаны
Ажиглалт автоматжуулалтын хэсгийн техник
ашиглалтын тасгийн ахлах инженер

Гишүүд:

Г.Мөнхбат Холбоо, навигаци, ажиглалтын албаны
Ажиглалт автоматжуулалтын хэсгийн техник
ашиглалтын тасгийн инженер

Б.Зориг Холбоо, навигаци, ажиглалтын албаны
Ажиглалт автоматжуулалтын хэсгийн техник
тасгийн инженер

Б.Энхмөнх Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний
албаны Бүсийн нислэгийн хөдөлгөөний
удирдлагын хэсгийн ерөнхий нислэгийн
удирдагч

Р.Одхүү Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний
албаны Бүсийн нислэгийн хөдөлгөөний
удирдлагын хэсгийн технологийн
мэргэжилтэн

Хяналтын инженер:

Д.Доржмягмар Холбоо, навигаци, ажиглалтын албаны
Ажиглалт автоматжуулалтын хэсгийн техник
ашиглалтын тасгийн ахлагч инженер